



# СОЁМБО

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№98 /542/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.06.16

Цаг үе, үйл явдал

## ГОВЬ ГУРВАН САЙХАН УУЛЫН ИХ ТАХИЛГАТ ХАЙРХНЫ ТЭНГЭРИЙГ ТАЙХ ЁСЛОЛ БОЛОВ



Өмнөговь аймгийн Говь гурван сайхан уулын Зүүнсайхан ууланд орших Их тахилгат хайрхны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслол 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр болов.

Тахилгын ёслолын өмнөх орой лам нар Итгэл, Ганданлажаа, Өлзийхутаг буулгах сан болон Долоон бурхан од тус бүрд тахилгын ном хурав.

Их тахилгат хайрхны тэнгэрийг тайх ёслол эхлэх үед "Ганжуур" их хөлгөн судар, Найман тахилгыг тусгайлан залж, лам хуврагууд Ламчодов, Жигжид, Очирваань, Юлтий зэрэг ном хурлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх төрийн бэлгэдлийг илэрхийлж,

төрөх монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн дээдэлж, ой, усны нөөцийг нэмэгдүүлэхэд хүн бүр хувь нэмрээ оруулахын чухлыг тэмдэглэв.

Мөн "Говь нутаг өрнүүн хөдөлмөр, их бүтээн байгуулалтын талбар болж, улс орны хөгжил дэвшил, хүн ардын амьдралд бодитой хувь нэмрээ оруулж, урагшлах урам зориг, дэвжих итгэл найдварын өлгий болж байна.

Өмнийн говийн зон олон нутгийнхаа эрдэс баялгийн хишиг буяныг хүртэж эхэлснээр нутаг орноо хөгжүүлж, амьдрал ахуйгаа өөд нь татан, улс орон, ард түмнийхээ хөгжил дэвшилд

Дараа нь Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Тэргүүн хамба Д.Чойжамц тэргүүтэй лам хуврагууд Буман цагаан судар, Их тахилгат хайрхан уулсын сан, Дэвжид сэргим, Жанлав цогзол ном уншиж, мандал өргөв.

Монгол Улсын Ерөнхийлөгч тэнгэрт хүргэх дуут сумыг Өмнөговь аймгийн Номгон сумын харьяат, Монгол Улсын даяар дуурсагдах мэргэн Ж.Баттөмөрт хүлээлгэн өгч, тус аймгийн Хүрмэн сумын Хүрмэн багийн малчин Г.Нямдоржийн адуун сүргээс сонгосон морийг тэнгэрийн хүлэг болгон сэтэрлэв.



Монгол Улсын Төрийн далбаа, Бүх цэргийн Их хар сүлдний Умарын элч сүлд, Өмнөговь аймгийн далбаа, Чингис хааны хөрөг болон Төрийн долоон эрдэнийг буцааж залснаар Их тахилгат хайрхны тэнгэрийг тайх гуравдахь удаагийн төрийн тахилгын ёслол өндөрлөв.

Говь гурван сайхан уулын Их тахилгат хайрхны тэнгэрийг Өгэдэй хааны үеэс тахиж байсан түүхтэй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны

08 дугаар сарын 23-ны 153 дугаар зарлигаар Говь гурван сайхан уулын Зүүнсайхан ууланд орших Их тахилгат хайрхныг төрийн тахилгатай болгосон юм.

Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос баруун тийш 180 километр цувран үргэлжилсэн хэд хэдэн нуруунаас тогтох Баруунсайхан, Дундсайхан, Зүүнсайхан хэмээх гурван том нурууг Говь гурван сайхан уул гэдэг.

Хамгийн өндөр нь Зүүнсайхан уул бөгөөд далайн түвшнээс дээш



үнэтэй хувь нэмэр оруулж буй аймаг" гэлээ. Ерөнхийлөгчийг үг хэлсний дараа туульч Алтайн магтаал хайлав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хэвлэлийн төлөөлөгч бөгөөд Хэвлэл мэдээллийн албаны дарга Ө.Золбаяр Их тахилгат хайрхны тэнгэрт хандсан айлтгалыг дуудан сонгож, торгон дээр бичсэн эх хувийг нь аймгийн музейд хадгалуулахаар хүлээлгэн өглөө.

2,846 метр. Энэ ууланд Ёлын ам, Мухар шивэртийн ам, Улиастай ам, Тосонгийн ам, Дүнгэнээгийн ам зэрэг үзэсгэлэнт газар олон.

Баруунсайхан ууланд 400 сая жилийн өмнөх мантийн чулуулаг ил гарсан сонин тогтоц бүхий газар байдаг. Үүнээс гадна дөрөвдүгээр сарын сүүлээр монгол сакура буюу буйлс цэцэглэдэг юм. Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрыг 1993 онд байгуулж, Баяндалай, Сэврэй, Булган, Хүрмэн, Гурвантэс сумын нийт 2,700 орчим га талбайг хамруулжээ.



хүндэт харуулын дөрвөн цэргээр хамгаалуулан тусгайлан зассан талбайд хүрэлцэн ирэв.

Дараа нь хүндэт харуулын цэргүүд Монгол Улсын Төрийн далбаа, Бүх цэргийн Их хар сүлдний Умарын элч сүлд, Өмнөговь аймгийн далбаа, Их эзэн Чингис хааны хөрөг, Төрийн долоон эрдэнийг тахилын ширээнээ залж байрлуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгч хэлсэн үгэндээ, уул овооны тэнгэрийг тайх ёслол нь түүх соёлын өв, төрт ёсны гүн уламжлал шингэсэн эрхэм нандин зан үйл гэдгийг тодотгов.

Мөнх хөх тэнгэртээ сүсэлж, хөрст дэлхийгээ шүтэн, байгальтайгаа эвсэн найрсаж, уул ус, ургамал модоо амьтай, эзэнтэй хэмээн хайрлан дээдэлж ирсэн нүүдэлчин монгол түмний соёл иргэншлийн гайхамшиг, давтагдашгүй онцлог гэдгийг хэлэв.

Байгаль эхээ хайрлан хамгаалж аж

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀ 23	🌙 9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀ 39	🌙 27

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,432	3,439
EUR 🇪🇺	3,696	3,717
CNY 🇨🇳	477	480
RUB 🇷🇺	40.90	41.10
JPY 🇯🇵	24.50	24.90
KRW 🇰🇷	2.70	2.72

### ЗУРХАЙ

2023.06.16 /БААСАН ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 28

**ЗУНЫ ТЭРГҮҮН УЛААГЧИН  
МОГОЙ САР  
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ  
ХӨХӨГЧИН МОГОЙ ӨДӨР**

Үс засуулбал:

**Хэрүүл тэмцэл ирнэ  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
04.52-20.53  
Барилдлага:  
Шид  
ШҮТЭН БАРИЛДЛАГА:  
Хүрэлцэхүй**

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Шүтээн босгох, хот балгадыг барих, тариа тарих, худалдаа наймаа хийх, шид бүтээл үйлдэх тарни тоолох болон дэлгэрүүлэх үйл бүхнээ сайн болой, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,231,235

Эдгэрсэн

Нийт: 662,757,344

Нас барсан

Нийт: 6,893,801

Цахим шууданд

ХУРАНДАА Ж.ӨСӨХБАЯР ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 167 ДУГААР АНГИД АЖИЛЛАЛАА



бэлтгэл ажил болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн барилгачин дайчдын барьж байгаа цэргийн гал тогооны барилгын явцтай танилцсан юм.

Мөн ангийн бие бүрэлдэхүүнд батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний зорилго, зорилт, үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэж, ажил албандаа итгэл үнэмшил дүүрэн, сахилга баттай, хөдөлмөрийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг ягштал баримталж ажиллахыг захисан юм.

Ахлах дэслэгч Б.БАТЗАЯА



ЗХЖШ-ын нэгдүгээр Цэргийн гавьяаны одонт орлогч дарга нэгдүгээр хурандаа Ж.Өсөхбаяр өнөөдөр БНМАУ-ын баатар, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит Тэрээр 50 жилийн түүхт ойгоо угтсан бүтээн байгуулалт,

ЯПОН УЛСЫН ЦЭРГИЙН ИНЖЕНЕРҮҮДЭД ҮНДЭСНИЙ СОЁЛ УЛАМЖЛАЛАА СУРТАЛЧИЛЛАА



баяр хүргэсэн юм.

Хүчит 32 бөхийн барилдааныг Монгол Улсын заан, ахмад Б.Батмөнх тайлбарлаж, дэд ахлагч Б.Ганбаатар түрүүлж, сумын заан, ахлагч Б.Батзаяа үзүүлэв. Үндэсний сурын харваанд монгол, япон инженерүүд цэц мэргэнээ сорин оролцсоноос тэргүүн байрт ахлагч Б.Батзаяа, дэд байрт Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний сургалтын багийн дэд ахлагч Араски шалгарч, хурсан олныг баясгалаа.



Хөгжөөнт буухиа тэмцээнд хоёр орны цэргийн алба хаагчид ур чадвар, хурд хүчээ сорин өрсөлдөхөд Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний сургалтын багийн дэслэгч Сасаки ахлагчтай баг тамирчид тэргүүлсэн юм.

Арга хэмжээний төгсгөлд Япон Улсын Батлан хамгаалах яамны мэргэжилтэн Хомма Минору "Монголчуудын түүх уламжлал үнэхээр гайхамшигтай юм. Дахин давтагдашгүй соёл уламжлалтай ард түмэн. Энэ дэлхийгээс өөр хаанаас ч хайгаад олохгүй. Соёлын арга хэмжээ бол манай дайчдын хүсэн хүлээдэг хөтөлбөрийн нэг. Монгол түүх уламжлалаа сурталчилсан мөрдэс нэгт нөхдөө баярлалаа" хэмээн талархал дэвшүүлж, ЦДБЭЧ-ын уран бүтээлчдийн тоглолтыг үзэж сонирхсон юм.

Ахмад Г.МӨНХБОЛД

Монгол Улсын Зэвсэгт хүчин, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний инженерийн салбарын хамтарсан "Зам-2023" сургуулийн хоёрдугаар шат Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийг түшиглэн амжилттай явагдаж байна. Сургуулийн үеэр зохион байгуулагддаг уламжлалт арга хэмжээ нь монгол, япон инженерүүдийн гар нийлэмжтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монгол Улсын үндэсний өв соёл, уламжлалыг сурталчлах зорилготой "Соёлын өдөрлөг" юм.



Уламжлал болсон энэхүү өдөрлөг 6 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдаж, монголчуудын өв уламжлалыг илэрхийлсэн "Бэсрэг наадам" болон ЦДБЭЧ-ын урлагийн тоглолтоор үргэлжилж, сургуулийн удирдагч ХЗЦК-ын Инженерийн дарга, дэд хурандаа Г.Мөнхбат, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа Г.Дүнжингарав, Япон Улсын Батлан хамгаалах яамны мэргэжилтэн Хомма Минору нар хоёр орны инженерийн цэргүүдэд



ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЦАХИМААР ЯВУУЛАХ ТУХАЙ



БНСУ-д явагдаж буй НҮБ-ын "UNMISS" энхийн сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний Мотоуудлагын батальоны 13 дугаар ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүний сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, шударга, ёс зүйтэй байдлыг ханган, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байхаар зохицуулах, зохион байгуулах зорилгын хүрээнд "Энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтын систем"-ийг боловсруулж, зохион байгуулалт, техникийн бэлэн байдал хангагдлаа.

Интернэтэд холбогдсон компьютер, гар утас бусад төхөөрөмжөөс аль нэг веб хөтөч ашиглан <https://psod.maf.gov.mn> мн домэйнээр эсвэл дараах QR кодыг уншуулан "Энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтын систем"-д хандана.

Энхийг сахиулах ажиллагааны сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид болон баримт бичгийн бүрдэлд хяналт тавих

анги, байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүд системтэй ажиллах өөр өөрийн түвшинд холбогдох заавартай дараах QR кодыг уншуулж танилцан, зааврын дагуу ажиллана уу.

Цахим хүсэлтийг зөвхөн 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 00 цаг хүртэл Энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтын систем ([psod.maf.gov.mn](https://psod.maf.gov.mn))-ээр хүлээн авах тул та бүхэн бүртгэлдээ идэвхтэй хамрагдана уу.

"Энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтын систем"-ыг боловсронгуй болгох, ашиглалттай холбоотой саналыг ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн [psod@mil.gov.mn](mailto:psod@mil.gov.mn) цахим шуудангаар илгээж болно. Системийн алдаа, ашиглах заавартай холбоотой асуудлыг /3888, 92113255/ дугаарын утсаар холбогдож тодруулахыг хүсье.

ЭНХИЙГ ДЭМЖИХ, ЦЭРГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

ХЭРЛЭНГИЙН ХӨДӨӨ АРАЛД СЭТГЭЛ ЗҮЙН БҮЛЭГ АЖИЛЛАВ



ЗХЖШ-ын Суртал хүмүүжил, сэтгэл зүйн хангалтын хэлтсийн дарга хурандаа Ү.Хүрлээгээр ахлуулсан Сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлэг энэ сарын 11-12-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 232 дугаар ангид ажиллав.

Сургалтыг баг, хамт олны оролцоонд суурилсан дасгал ажил, тоглоом, бүлгийн хэлэлцүүлэг зэрэг шинэлэг аргаар зохион байгуулсан юм.

Энэ үеэр хурандаа Ү.Хүрлээ Зэвсэгт хүчний Жанжин штабаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх тавьсан мэдээлэлдээ "Зэвсэгт хүчний ирээдүйн өнгө төрх нь та бидний сэтгэл зүйн тогтвортой байдлаас шалтгаална" хэмээсэн

нь энэхүү сургалтын гол "түлхүүр" болсон юм.

Энэхүү хөдөлгөөнт бүлэг нь алба хаагчдаас хувь хүний сэтгэл түгшилт, сэтгэл гутрал, сэтгэлийн хямрал, стресс зэрэг сэтгэл зүйн багц судалгааг авсны зэрэгцээ "Бүлэг, багт би хэн бэ?", "Харилцааны хэв шинж", "Харилцааны хэлбэр", "EQ" зэрэг чадваруудыг тодорхойлох сорилыг авсан юм. Мөн сэтгэл зүйн байдал, тулгамдаж байгаа асуудлуудад дүн шинжилгээ хийж, сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөг өгсөн нь анги, хамт олны уур амьсгалд эерэг нөлөө үзүүлсэн үр дүнтэй сургалт боллоо.

О.ЭГШИГЛЭН